



Баталгаатай мэдээлэл амьдралыг аварна!

**“ХЯМРАЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА:
ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА-II”**
төслийн хэрэгжилтийн тайлан



Reliable
information
saves lives





Төслийн тухай

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яамны (BMZ) дэмжлэгтэйгээр олон улсад хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Дойче Велле Академитай (DWA) хамтран “Хямралын мэдээллийн харилцаа, оролцогч талуудын хамтын ажиллагаа” төслийг хоёр дахь жилдээ хэрэгжүүллээ.

Төсөл нь нийтийг хамарсан хямрал, эрсдэл, гамшгийн үед иргэд, олон нийтийг баталгаатай мэдээллээр хангах байдлаар мэдээллийн тэгш бус байдлыг бууруулахад хэвлэл мэдээлэл, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага болон олон нийтийн төлөөллүүд хамтарч, өөрсдийн мэдлэг, харилцаа холбоогоо нэгтгэн, мэдээллийг нягтлах, хариуцлагатайгаар түгээх баг болон ажиллахад чиглэсэн.

Уг төсөл нь Кени, Замби, Киргиз, Молдав, Монгол зэрэг улсуудад хэрэгжсэн бөгөөд Монгол Улсын тухайд төслийн хэрэгжүүлэгчээр Хэвлэл мэдээллийн зөвлөл хоёр дахь жилдээ ажиллаад байна. Төслийн хүрээнд тус бүр 9 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааны багууд байгуулагдаж, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо болон Сэлэнгэ аймагт мэдээлэл харилцааны бичил төслийг хэрэгжүүлсэн юм.

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь иргэдийн мэдэх эрхийг хангах, ёс зүйтэй, баталгаатай, найдвартай мэдээллийг түгээн дэлгэрүүлж, хэвлэлийн эрх чөлөөг бататган хамгаалахад хувь нэмрээ оруулдаг салбарын өөрийн удирдлагын байгууллага билээ. Энэ зорилгынхоо хүрээнд мэдээллийн хоёр чигт урсгалыг дэмжих, мэдээллийн хүртээмж сул, алслагдсан хороо, сумдын иргэдэд баталгаат мэдээллийн үнэ цэнийг ойлгуулах, худал ташаа мэдээллийн хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх, мэдээллийн харилцаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжихэд хувь нэмрээ оруулж буй юм.



Төслийн үйл ажиллагаа, үр дүн

2022.06-07 сар

**Төслийн үзэл
баримтлал,
ач холбогдлыг
хэлэлцлээ**



Хямралын үеийн мэдээлэл харилцаанд талууд хамтран ажиллах нь яагаад чухал болох, баталгаатай мэдээллийг түгээхийн тулд баримт нягтлагчид болон хэвлэл мэдээллийнхэн олон улсад хэрхэн ажиллаж буй туршлагатай танилцах, санал солилцох хэлэлцүүлгийг сэтгүүлч, редакторуудын дунд хоёр удаа зохион байгуулав. Эдгээр уулзалт нь “Дайн, зэвсэгт мөргөлдөөний үеийн хэвлэл мэдээллийн ёс зүй”, “Хуурамч мэдээлэлтэй тэмцэж буй олон улсын туршлага” зэрэг сэдвийн хүрээнд болсон бөгөөд аливаа хямралын үед хэвлэл мэдээлэл, баримт шалгагчид, төрийн байгууллагынхан, судалгааны хүрээлэнгүүд, иргэд, иргэний нийгэм зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагаа чухал болохыг онцлон тэмдэглэсэн билээ.





2022.08-09 сар

Төсөл хэрэгжих зорилтот газрыг тодорхойлов



Төсөл хэрэгжих зорилтот хороог тодорхойлох уулзалт, ярилцлагыг цувралаар зохион байгуулж, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо болон Сэлэнгэ аймгийг төсөл хэрэгжүүлэх талбар, нэгжээр сонголоо.



Дотоодын сургагч багш нарыг сонгон шалгаруулаа



Үйл ажиллагааны багт хямралын мэдээллийн харилцааны чадавхжуулах сургалтыг зохион байгуулах дотоодын сургагч багш нарыг сонгон шалгаруулав.



А.Ариунтуяа

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн төслийн зохицуулагч, сургагч багш



Э.Батцэцэг

Монголын баримт шалгагчдын төвийн ерөнхий редактор



Б.Дуламхорлоо

Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн үүр төвийн тэргүүн



Ц.Тамир

Фактчек Монгол сүлжээний үүсгэн байгуулагч, баримт нягтлагч



Ц.Чимиддондог

Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийн сургагч багш



2022.10-11 сар

Багш нарыг
чадавхжуулах
сургалт болов



ХБНГУ-ын Дойче Велле Академийн сургагч багш Сюзанна Молл, Наталья Раймер нар манай улсад ирж, дотоодын сургагч багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгууллаа. Сургалтын агуулга нь нийтийг хамарсан хямрал, онцгой байдлын үед төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл гэсэн бүтэцтэйгээр мэдээлэл харилцааны ажлыг зохион байгуулахад, харилцан ойлголцоход шаардагдах агуулгыг үр дүнтэй хүргэхэд чиглэж байв



Сургалтын
хөтөлбөрийг
шинэчиллээ



Дотоодын сургагч багш нар олон улсын туршлага болон Монгол Улсын онцлогт тулгуурлан аямрал, онцгой байдлын үед ажиллах хамтарсан багийг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг шинэчиллээ. Хөтөлбөр нь “Хямралын мэдээллийн харилцаа”, “Хямралын үеийн талуудын үүрэг, оролцоо”, “Мэдээллийг оновчтойгоор хүргэх аргууд”, “Мэдээллийг нягтлах, үнэлэх”, “Хүртээмжтэй харилцаа холбоо тогтоох” зэрэг агуулга бүхий 32 багц цагаас бүрдсэн.



2022.10 сар - 2023.01 сар

Үйл ажиллагааны
багууд бүрдэв




Чингэлтэй дүүргийн 17 дугаар
хороонд үйл ажиллагаа
явуулах баг

Төр, хэвлэл мэдээлэл, иргэд/иргэний нийгмийн тэнцүү төлөөлөл бүхий тус бүр есөн гишүүнтэй Үйл ажиллагааны багуудыг үүсгэлээ.

- Төрийн байгууллагыг төлөөлж: ЦХХХЯ-ны Харилцаа холбоо, гамшгийн хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Отгон, ҮАБЗ-ийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэнгийн Ахлах шинжээч Д.Дагийсүрэн, ЧД-ийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн Д.Ариунзаяа,
- Хэвлэл мэдээллийг төлөөлж: Тэнгэр ТВ-ийн сэтгүүлч, продюссер Б.Батцэнгэл, Зууны мэдээ сонины сэтгүүлч П.Амгаланбаяр, GoGo.mn сайтын сэтгүүлч А.Наранцацрал,
- Иргэд, зорилтот хороог төлөөлж: ЧД-ийн 17 дугаар хорооны Нийгмийн ажилтан М.Мөнхзул, Ерөнхий боловсролын 37-р сургуулийн Нийгмийн ажилтан Н.Батболд, хорооны иргэн Ч.Энхцэцэг



Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулах баг



- Төрийн байгууллагыг төлөөлж: Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Ганчимэг, Хилийн цэргийн 0243-р ангийн Захирагчийн орлогч, сэтгэл зүйн хангалтын дарга, дэд хурандаа Н.Ганбат, Сэлэнгэ аймгийн ГИХХБДГ-ын Хяналтын улсын байцаагч Ш.Даринчулуун;
- Хэвлэл мэдээллийг төлөөлж: Сэлэнгэ аймгийн цахим ТВ, ФМ 107.5-ийн эрхлэгч Д.Туул, Сэлэнгийн мэдээ сонин, Монцамэ агентлагийн сурвалжлагч Ч.Отгонцэцэг, Аймгийн ЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн ажилтан Д.Одонтунгалаг;
- Иргэд, зорилтот хороог төлөөлж: Сэлэнгэ аймаг дахь Монголын үйлдвэрчний эвлэлийн тэргүүн Э.Саранчимэг, Хөгжлийн хүч ТББ-ын нарийн бичгийн дарга Э.Намуунцэцэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоог төлөөлж Г.Отгон;





Үйл ажиллагааны багуудыг чадавхжуулах сургалтууд боллоо



Дотоодын сургагч багш нараар удирдуулсан чадавхжуулах сургалтууд явагдлаа. Сургалт нь онол болон практик хосолсон, суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, дотоодын болон олон улсын жишээг агуулсан байснаараа онцлогтой байв.




Сэлэнгэ аймаг




Чингэлтэй дүүрэг

Таван улсын цахим уулзалтад оролцов



Тус төсөл хэрэгжиж буй бусад орнууд болох Кени, Замби, Молдав, Киргизстан улсын төслийн багтай туршлага солилцох цахим уулзалтад оролцож, Монгол Улсын багийн үйл ажиллагааг танилцууллаа. Уулзалтын үеэр талууд чадавхжуулах сургалтаас сурч мэдсэн зүйлсээ ярилцаад, үүндээ тулгуурлан зорилтот бүлгүүдэд хэрхэн мэдээлэл түгээж буй туршлагаа хуваалцав.

Кени Улсын тухайд сонгуулийн дараа үүссэн улс төрийн тогтворгүй байдал, хямралыг даван туулах, Замби Улс Ковид-19 цар тахлын эсрэг вакцинжуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байв. Харин Молдав Улсын баг эрчим хүчний хомсдолоос үүдсэн хямралын үед иргэдийн мэдэж байвал зохих мэдээллийг түгээж эхэлсэн бол Киргизийн тухайд үнийн өсөлтийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хандсан төсөл тус тус хэрэгжүүлжээ.





2023.02-03 сар

**МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭЭ**

**НЭГ. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
17 ДУГААР ХОРОО**

***Төсөл хэрэгжих зорилтот
газартай танилцах аялал
зохион байгуулав***

***Үйл ажиллагааны
төлөвлөгөө, хуваарь гаргав***

Хямралын мэдээллийн харилцааны бичил төсөл хэрэгжүүлэх Үйл ажиллагааны баг II нь төсөл хэрэгжүүлэх зорилтот газар болох Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороотой танилцах аялал хийв. Баг нь тус хороо, иргэдийн төлөөлөлтэй уулзаж, мэдээлэл түгээж буй болон хүлээн авч буй байдал, түгээмэл ашигладаг сувгууд, тэдгээрийн хүртээмжийн талаар судаллаа. Түүнчлэн хороонд тулгамдаж буй гамшиг, эрсдэлийн асуудлыг хэлэлцсэн юм.



Багийн гишүүд зорилтот бүлэгт хандсан мэдээлэл харилцааны ажлаа төлөвлөх, хэрэгжүүлэх уулзалтуудыг цувралаар зохион байгуулав.







Мэдээллийн багцыг бэлтгэн хэрэгжүүлээ

Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны оршин суугчдад “Цахим орчин дахь худал мэдээллийг ялган таних” болон “Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх” гэсэн сэдвийн хүрээнд мэдээллийн багц бэлтгэн түгээлээ. Эдгээр нь:

- Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэдэд мэдээлэл түгээх үүрэгтэй ажилладаг албан хаагчид, хэсгийн ахлагч нар, иргэдийн төлөөлөлд “иргэдийн дунд тархсан түгээмэл худал мэдээллийг тодорхойлох, цахим орчин дахь мэдээллийг нягтлах, баталгаатай мэдээллийг ялган таних” зэрэг агуулгын хүрээнд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.






Сургалт, хэлэлцүүлгийн үйл ажиллагааг сурвалжилсан телевизийн мэдээ, сонин болон сайтын сурвалжилга тус бүр нэгийг гаргаж олон нийтэд түгээв.

Сургалтад оролцогчдын санал, сэтгэгдлийг багцлан постер болгож, цахим орчинд (Crisis Communication Chapter - Mongolia төслийн болон Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны фэйсбүүк хуудас, группүүд) түгээлээ.

Хорооны нутаг дэвсгэрт байрладаг Нийслэлийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад "Цахим орчин дахь худал мэдээллийг хэрхэн ялган таних вэ" болон "Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтээс хэрхэн сэргийлэх вэ" сэдвийн хүрээнд цахим хичээл бэлтгэж, сурагчдад үзүүлэв.

Цахим хичээлийн талаарх сэтгэгдлийг сурагчдаас тодруулж, сурвалжилга бэлтгэн түгээлээ.





“Цахим орчин дахь худал мэдээллээс үүдэлтэй үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоо” сэдэвт захидлын уралдааныг сурагчдын дунд зарлав. 250 орчим сурагчид оролцсон өргөн хэмжээний уралдаан боллоо.

Захидлын уралдааны шилдгүүдийг тодруулж, цахим орчин дахь худал мэдээлэл болон үе тэнгийн дээрэлхэлтийн сөрөг үр нөлөөг танилцуулсан өдөрлөгийг сурагчдыг хамруулан зохион байгуулав.

Дуучин, хүүхдийн элч С.Гантогоо сурагчдын өдөрлөгт оролцож, ая дуугаа өргөхийн зэрэгцээ үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг байхыг уриалж, сошиал медиа, бусдын ярианаас бус баталгаатай эх сурвалжаас мэдээлэл авч байхын чухлыг сурагчдад хандан хэлсэн юм.







gogo Мэдээ GoGo Руслан Үзэх Холдинг English

С.Гантоого: Дээрлэхэж байгаа болон дээрлэхүүлж буй хүүхэд хошулаа ХОХИРОГЧ


А.Морин дэ гэдэ

100% 100%



Өдөрлөгийн үйл явцыг сурвалжилсан нийтлэл GoGo.mn сайтад гарав.

Сурагчдын болон багш, эцэг эхчүүдийн санал, сэтгэгдлийг эмхэтгэн цахим орчин дахь худал мэдээлэл, үе тэнгийн дээрлэхэлтийн сэдвийг хөндсөн 2 видео нэвтрүүлэг болон цахим постеруудыг бэлтгэж цахим орчинд цацлаа.



Нийслэлийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургуулийн санаачилгаар “Цахим орчин дахь худал мэдээлэл болон сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрлэхэлтийг бууруулах нь” сэдэвт сургалт, видео шторкийн уралдааныг зохион байгууллаа.





Цахим орчин дахь худал мэдээллийг ялган таних” болон “Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх” сэдвийн хүрээнд зохион байгуулсан дээрх үйл ажиллагаанд үндэслэн сурагчдын дунд үе тэнгийн нөлөөлөгчдийг бэлтгэх сургалт, үйл ажиллагаа зохион байгууллаа.



Дээрх үйл ажиллагааны үр дүнд худал мэдээлэл, дээрэлхэлтийн эсрэг үйл ажиллагаа явуулах “Wall-E” клуб байгуулагдав.



Клубийн гишүүд ахлагч болон дэд ахлагчдаа



Цай үе

Н.Болортуулал: Богино хугацаанд хэрэгжсэн 4 үр дүнтэй төсөл байлаа

БАГАЛГААН

Хувьд мэдээллийн технологийг "Хэрэгжүүлэх хамтын ажиллагаа" олон үзэмж төслийн нэгдэл болж хөгжүүлж байна. Энэ үр дүнтэй төсөл мэдээллийн технологийг бүхэл бүтэн хэрэгжүүлэхэд чиглэсэн төслийн амжилттай хөгжүүлэлт "Баталгаатай амьдрал" уриан дор хэрэгжсэн үр дүнтэй төсөл болж бүтэцтэй болжээ. Тус төслийн хамтын ажиллагаа "Баталгаатай амьдрал" уриан дор хэрэгжсэн үр дүнтэй төсөл болж бүтэцтэй болжээ. Тус төслийн хамтын ажиллагаа "Баталгаатай амьдрал" уриан дор хэрэгжсэн үр дүнтэй төсөл болж бүтэцтэй болжээ.



Төслийн үр дүнг хэрэгжүүлж байна. Энэ үр дүнтэй төсөл мэдээллийн технологийг бүхэл бүтэн хэрэгжүүлэхэд чиглэсэн төслийн амжилттай хөгжүүлэлт "Баталгаатай амьдрал" уриан дор хэрэгжсэн үр дүнтэй төсөл болж бүтэцтэй болжээ. Тус төслийн хамтын ажиллагаа "Баталгаатай амьдрал" уриан дор хэрэгжсэн үр дүнтэй төсөл болж бүтэцтэй болжээ.

Сурагчдын "Wall-E" клуб байгуулагдсан тухайг өгүүлсэн нийтлэл, видео нэвтрүүлэг, сошиал медиа постерууд гарч, олон нийтэд түгээлээ.

"Баталгаатай мэдээлэл амьдралыг аварна" гарын авлагыг бэлтгэн, 3000 хувь хэвлэж гаргалаа. Гарын авлагыг сурагчдын "Wall-E" клуб, 37 дугаар сургууль, Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо болон хорооны номын санд гардуулан өгсөн юм.



Мэдээллийн багцын үр дүнг дүгнэх уулзалтыг Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны удирдлагуудтай хийж, төслийн үйл ажиллагааны залгамж халааг хадгалах талаар ярилцлаа.






ХОЁР. СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМ

*Үйл ажиллагааны
төлөвлөгөө, хуваарь гаргав*

*Мэдээллийн багцыг
бэлтгэн хэрэгжүүлээ*

Багийн гишүүд зорилтот бүлэгт хандсан мэдээлэл харилцааны ажлаа төлөвлөх, хэрэгжүүлэх уулзалтуудыг цахимаар болон танхимаар зохион байгуулж ажиллав.



Сэлэнгэ аймаг дахь үйл ажиллагааны баг нь Алтанбулаг сумын Цөх багийн малчин иргэд, хилчдийн дунд хилийн орчимд мал бэлчээхтэй холбогдон үүсдэг маргаан, зөрчлийг шийдвэрлэхэд чиглэж ажиллалаа. Энэ хүрээнд:

Малчид, хилчдийн дунд бэлчээртэй холбоотой үүссэн зөрчлийг шийдвэрлэх, нэгдсэн ойлголцолд хүрэхийн тулд иргэд/малчид, сумын засаг захиргаа, хилийн цэргийн алба гэсэн гурван талт уулзалтыг зохион байгуулав.





Гурван талт уулзалт болсон тухай видео мэдээг аймгийн сошиал сувгуудаар болон Монцамэ.мн сайтад гаргасан.




Д.БАЛЖИННЯМ
Цох багийн малчин



Хилийн бүс нутагт мал маллах хэцүү, малаа хил давуулж байсан үе бий. Гурвалсан гэрээ байгуулаад энэ торон дотор малаа оруулах эрх авсан. Өвлийн цагт малаа нэг зүгт бэлчээх шаардлагатай болоод байдаг, зун, хавар бол бэлчээр байгаа. Малчдаа харж үздэг хилчдэдээ их баярладаг. Малаа хариулах өдрөө маш хариуцлагатай байх ёстой. Аймгийнхаа бодлого шийдвэрийг хүндэтгэн цөөн тооны ашиг шимтэй малтай болохыг хичээж байна. Үхрийнхээ тоог 50-100, бөг малаа 500-д барих боломж бий.

Сэлэнгэ CCC баг

Мал бэлчээртэй холбоотой хилийн зөрчлийг багасгах, малчдад хууль эрх зүйн мэдлэг олгох зорилготой видео нэвтрүүлгийг бэлдэж зорилтот бүлэгт түгээлээ.






“Сэлэнгийн мэдээ” сонины тусгай дугаарыг 1000 хувь хэвлэж, зорилтот бүлэг болон аймгийн хэмжээнд тараав.



Үйл ажиллагааны багийн гишүүд болон мэдээлэл харилцааны ажлын зорилтот бүлгийн төлөөллийн дуу хоолойг илтгэсэн цахим постеруудыг бэлтгэн түгээлээ.



Э.ЭЛЗИЙБАЯР
Хилийн цэргийн
салбарын захирагч

Манай застав Алтанбулаг сумаас зүүн тийш нийт 32 км хэсгийг хариуцдаг. Хилийн зурваст иргэн, малчин хариулгагүй малаа бэлчээрлүүлсэн тохиолдолд хилийн орчимд дэглэмийн зөрчил болоод явдаг. Манай хариуцсан хэсэгт 8 айлын 300-400 орчим үхэр байдаг. Эдгээрийг сумын Засаг дарга, багийн дарга нарын хүсэлтээр хилийн торонд хариулуулснаар хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил буурсан. Энэ бол нэлээд үр дүнтэй ажил болсон.

Сэлэнгэ CCC баг

Баталгаатай
мэдээлэл
амьдралыг
аварна.



Н.ГАНБАТ
Захирагчийн орлогч,
сэтгэл зүйн хангалтын
дарга, дэд хурандаа,
Сэлэнгэ CCC багийн
 гишүүн

Төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн уялдааг холбоог хангаж ажиллахад учирч буй саадыг олж харлаа, харилцан ойлголцол, хамтын ажиллагаа маш чухал юм байна.

Сэлэнгэ CCC баг

Баталгаатай
мэдээлэл
амьдралыг
аварна.



Б.ТӨРБАТ
Хилийн цэргийн
0243-р ангийн цэргэ

Мал хилд тулах асуудал байнга гардаг учир заримдаа хил хамгаалах биш, малчин хийгээд байна уу даа гэж болдог төрдөг. Хилд тулсан малыг илрүүлэн застав руугаа мэдэгдэж, үүрэг чиглэлийн дагуу нэг бол эзэнд нь хүлээлгэж огноо, эсвэл нааш нь татна. Бид үүргээ морьтой гүйцэтгэдэг, морьто 1-2 өдөр болоод амрах ёстой. Гэтэл өдөр бүр айлын мал туугаад байгаа болохоор морь амархан эцэж, ядарч, турдаг.

Сэлэнгэ CCC баг

Баталгаатай
мэдээлэл
амьдралыг
аварна.



Мэдээллийн багцын үр дүнг хэлэлцэх уулзалтыг төслийн багийнхан Сэлэнгэ аймгийн удирдлагуудтай хамтран хийж, цаашдын хамтын ажиллагаагаа ярилцав.






2023.03 сар

Төслийн үр дүнг олон улсад таницууллаа

Төслийн үр дүнг танилцуулах, хэлэлцэх уулзалт ХБНГУ-ын Бонн хотноо болж, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, төслийн менежер Н.Ганчимэг нар оролцов. Уулзалтад Кени, Замби, Киргиз, Молдав зэрэг орнуудын төлөөлөл ирж, харилцан туршлага солилцсон бөгөөд Монгол Улсад хэрэгжсэн төсөл нь аливаа хямрал, гамшиг, ослын үед төдийгүй нийгэмд тулгамдсан бүхий л асуудлыг шийдвэрлэхэд түшиглэж болохуйц хамтын ажиллагааны загварыг таниулснаараа ач холбогдолтой байлаа хэмээн үнэлэв.





Төслийг дүгнэх олон талт уулзалт болов

Төслийн үрдүнг дүгнэх, оролцогч талуудад таниулах, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох дугуй ширээний өргөтгөсөн уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад хөтөлбөрт оролцогч талуудын төлөөлөл болох хэвлэл мэдээллийн байгууллагууд, төрийн байгууллагууд буюу ОБЕГ, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэн болон бусад иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүд оролцсон бөгөөд тус хөтөлбөрийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжсэн хэмээн дүгнэлээ. ХМЗ-ийн удирдлагын зүгээс уг төслийн үзэл баримтлал, үйл ажиллагаа нь Монгол Улсад чухал хэрэгцээтэй учраас бодлого, тогтолцоонд суулгаж өгөх чиглэлд оролдлого хийж буй бөгөөд төсөл дууссан ч үргэлжлүүлэн хийсээр байх болохоо илэрхийлэв.





Хамтарсан ажлын хэсэг байгуулагдлаа

2022.09.29

Хямрал, гамшиг, ослын үед иргэдэд баталгаатай мэдээллийг түгээхэд чиглэсэн хэвлэл мэдээлэл, төр, иргэний нийгмийн оролцоо, зөвшилцөл бүхий үндэсний хэмжээний мэдээлэл харилцааны бүтэц байгуулах уулзалтуудыг зохион байгууллаа. Уулзалтуудын үр дүнд хямрал, онцгой байдлын үед ажиллах үндэсний хэмжээний мэдээлэл харилцааны бүтцийг бий болгох зураглал гаргах, холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулах төсөл боловсруулах зэргээр ажиллахаар тогтов. Энэ ажил төсөл дууссан ч үргэлжлэн хэрэгжих юм.



ТӨСӨЛД ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭГДЛЭЭС...



Зууны мэдээ сонины сэтгүүлч П.Амгаланбаяр:

“Хямралын үед гурван тал хэрхэн нэг баг болж ажиллах талаарх сургалтуудыг тодорхой цаг хугацаанд үр өгөөжтэй орсон учраас цаашид хамтран ажиллах том хөшүүрэг болсон гэж бодож байна. Мөн сургалтын үед хэвлэл мэдээлэл, төрийн байгууллага, иргэд өөрсдийн хийгээд бусад байгууллагын өнцгөөс асуудалд дүн шинжилгээ хийх дасгал ажлыг тогтмол хийж байсан нь бие биенээ ойлгох боломжийг олгож байсан.”



Стратегийн судалгааны хүрээлэнгийн ахлах шинжээч Д.Дагийсүрэн:

“Төсөлд хамрагдсанаар хэвлэл мэдээллийн салбарын хүмүүсийн үүрэг оролцоо нийгэмд ямар өндөр болохыг ойлголоо. Төрийн байгууллагын хувьд бусад оролцогч талуудтай хамтран ажилласанаар ямар их үр дүнтэй ажил хийж болохыг харсан. Судлаач хүнийхээ хувьд шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр төрийн албан тушаалтнуудыг хангахдаа мэдээ мэдээллийг маш сайн нягтлан шалгасны дараа хуваалцах ёстойг өөртөө тусгаж авлаа.”



Гадаадын иргэн харьяатын газрын хяналтын улсын байцаагч Ш.Даринчулуун:


“Сэлэнгэ аймгийг газар тариалангийн бүс нутаг болгон зарласан. Үүнээсээ болоод хилийн бүс нутагт мал бэлчээх газар хомсдолтой, тиймээс ч малчин өрхүүд хил орчимд малаа бэлчээхээс аргагүйд хүрч байна. Гэтэл энэ нь хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчилд тооцогддог. Нөгөө талаас хилийн зурвасын шонгууд амархан эвдэрдэг, мал хэд шөргөөгөөд унадаг, бат бөх материалаар хийх асуудлыг холбогдох байгууллага, аймгийн удирдлагын анхааралд өртүүлж чадсан гэж үзэж байна.”



Хилийн цэргийн дугаар ангийн захирагчийн орлогч, Сэтгэл зүйн хангалтын дарга, дэд хурандаа Н.Ганбат: “Төслийн сургалтад хамрагдсанаар төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллүүдтэй харилцан хамтран ажиллах шинэ боломжийг олж харсан. Энэ боломж бол иргэдэд зөв, хүртээмжтэй мэдээллийг өгөх, тэднийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд явуулж байгаа бодлого, шийдвэрийг хүргэх, мөн эргэх холбоо бүхий үр дүнтэй харилцааны сувгийг бий болгох гарц юм гэдгийг ойлгож авсан.”



CRISIS COMMUNICATION CHAPTER MONGOLIA



Төслийн үйл ажиллагааны талаар Фэйсбүүк дэх Crisis communication chapter-Mongolia хуудсаас авах боломжтой.

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН АЖИЛЛАСАН,
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД:**

Чингэлтэй дүүргийн ИТХ
Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо
Нийслэлийн ерөнхий боловсролын 37-р сургууль
GoGo.mn сайт
Тэнгэр телевиз
Зууны мэдээ сонин
Сэлэнгийн мэдээ сонин
Сэлэнгэ аймгийн ЗДТГ
Сэлэнгэ аймгийн цахим ТВ
Хилийн цэргийн 0243-р анги



70000160



info@mediacouncil.mn



www.mediacouncil.mn



[mediacouncilmongolia](https://www.facebook.com/mediacouncilmongolia)